

НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫГ ХАМРУУЛАН ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ.

Арга хэмжээ 1.

Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг “тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж байна.

Монгол Улсын Ойн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн хүрээнд хэрэгжүүлэх “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн “Ногоон хот-Иргэний оролцоо” хаврын мод тарих аяны нээлтийн өдрүүд 2023 оны 05 дугаар сарын 11-ны өдрөөс 05 дугаар сарын 19-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын ажилтан, албан хаагчид энэхүү аяны хүрээнд 2023 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, ТЭЦ-4-ийн урд байрлах “Баянгол цэцэрлэгт хүрээлэн”-д 170 ширхэг хайлаас мод тарьсан ба ургалт 90 хувьтай, суулгацын ургалт 10 см-аар нэмэгдсэн, хэлбэржүүлэлт хийгдсэн. 2022 оны намрын нөхөн тарилтаар 40 хайлаас тарьсан. Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын ажилтан, албан хаагчид энэхүү аяны хүрээнд 2023 оны 05 дугаар сарын 11-ны өдөр Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, ТЭЦ-4-ийн урд байрлах “Баянгол цэцэрлэгт хүрээлэн”-д 120 ширхэг хайлаас мод тариллаа.



Арга хэмжээ 2.

“ЭХ ДЭЛХИЙН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ ӨДӨР” АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ

Хог хаягдал, орчны бохирдлыг бууруулахтай холбоотой иргэдийн эрүүл аюулгүй цэвэр орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Эх дэлхийн цэвэрлэгээний өдөр” арга хэмжээг тохиолдуулан нийслэлийн хэмжээнд бүх нийтийн их цэвэрлэгээг 2023 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулсны дагуу Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын 123 ажилтан, албан хаагч бүрэн хамрагдсан.

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар нь Улаанбаатар хотын ерөнхий менежерийн баталсан нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын цэвэрлэх талбайн хуваарийн дагуу Сэлбэ голын баруун талын зам дагуу тодруулбал Арслантай

гүүрнээс Дамдинсүрэнгийн гудамжны гүүр хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбайн хог хаягдлыг цэвэрлэж 50 гаруй ширхэг шуудай хогийг түүж цэвэрлэн нийслэл хотынхоо өнгө үзэмж, цэвэр, эрүүл орчин бүрдүүлэх энэхүү арга хэмжээнд идэвхтэй оролцлоо.



Арга хэмжээ 3.

“ИРГЭДЭД ЭЭЛТЭЙ СТАНДАРТ” ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Стандарт, хэмжил зүйн салбарын 100 жилийн ойн баярыг тохиолдуулан Хотын стандартын тогтолцоог хөгжүүлэхэд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үүрэг, оролцоог сайжруулах, батлагдсан хотын стандартын талаарх мэдлэг ойлголтыг бэхжүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх зорилгоор Жанжин Д.Сүхбаатарын талбайд 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр “Иргэдэд ээлтэй Стандарт” өдөрлөг зохион байгуулагдлаа.

Тус өдөрлөгт Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд, дүүрэг хороодын албан хаагч нар, аж ахуйн нэгж байгууллагын ажилтнуудын төлөөлөл оролцсон бөгөөд Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газраас холбогдох албан хаагчид “UCS 0202B:2020 Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын цэвэрлэгээ, үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага” стандарт болон “Цахилгаан, сантехник, мужааны ажил гүйцэтгэхэд инженер, техникийн ажилтны аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага”-ыг стандартад нийцүүлэн өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байгаа талаар танилцууллаа.



Арга хэмжээ 4.

“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНД НЭГДСЭН ТУХАЙ

Ойн тухай хууль, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн хүрээнд хэрэгжүүлэх “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон хот-Иргэний оролцоо”

намрын мод тарих аяныг Нийтлэг үйлчилгээний газрын ажилтан, албан хаагчид 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдөр Баянгол цэцэрлэгт хүрээлэнд зохион байгууллаа. Тус аянд нийт 16 ажилтан, албан хаагч хамрагдаж өмнө нь тарьсан модны арчилгаа, усалгаа, нөхөн сэргээлтийн ажлуудыг хийж гүйцэтгэв.



Зураг 1. Модны арчилгаа, усалгаа хийх явцаас



Зураг 2. 2022 оны 05 дугаар сарын 18

Зураг 3. 2023 оны 10 дугаар сарын 09

Арга хэмжээ 5.

“ЦАСАА ЦЭВЭРЛЭЭ” АЯНД ОРОЛЦСОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН


Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас зохион байгуулсан нийтийн эзэмшлийн зам талбай, аж ахуй нэгж байгууллагуудын эзэмшил, талбайд хуримтлагдсан цас, хог хаягдлыг цэвэрлэх зорилготой “ЦАСАА ЦЭВЭРЛЭЭ” аяны хүрээнд цасны их цэвэрлэгээ “90 минут” арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа. Удирдамжийн дагуу 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдөр 11:00-12:30 цагийн хооронд нийт 142 ажилтан, албан хаагчийг хамруулан Төв шуудангаас Баруун дөрвөн зам хүртэлх хойд талын явган замын цас мөсийг цэвэрлэж, халтиргаа гулгааг арилгаж, нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд иргэд олон нийт зорчиход аюулгүй байдлыг ханган ажиллалаа.



Зураг 1. Төв шуудангийн урд хэсэг



Зураг 2. Автобусны буудал



Зураг 3. Мэргэжилтний 20-ийн автобусны буудал



Зураг 4. Мөнгөн завьяа автобусны буудал



Зураг 5. Баруун дөрвөн зам хүртэлх

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТ ХАРИУЦСАН АЖИЛТАН: А.НОМИНЗУЛ